



180

ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 1147

Шивээговь сум

Г Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2009 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбилцлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэх бүрдүүлэх” ажил хэрэгжүүлсэнтэй холбогдуулан иргэн Их монгол овогтой Ухнаагийн Хашгэрэл /EA82110308/ нь 2 дугаар баг, урд гэр хороололд байрлах 700м² газар худалдах худалдан авах гэрээний үндсэн дээр өмчилж авсан нь мэргэжлийн байгууллагаар суурин кадастрын зургийг хийхэд талбайн хэмжээ, хаяг өөрчлөгдсөн тул Их монгол овогт Ухнаагийн Хашгэрэлд 2 дугаар баг, Сэвхүүл-2 гудамжны 248 тоотод байрлах 1068 м² талбайтай, 1,495,200 (нэг сая дөрвөн зуун өрэн таван мянга хоёр зуу) төгрөгийн үнэ бүхий газрыг үнэ төлөргүйгээр өмчлүүлсүгэй.

2.Өмчилж авсан тухайн газраа улсын бүртгэлд бүртгүүлэхийг иргэн (Ухнаагийн Хашгэрэл)-д үүрэг болгосугай.

3.Газар өмчлөлийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ

